

## ЦАХИМ БИЧВЭРТ СУУРИЛСАН МОНГОЛ ХЭЛНИЙ ҮЙЛ ҮГИЙН БУСДЫН ЭРХЭНД ҮЙЛДЭГДЭХ ХЭВИЙН УТГА, ХЭРЭГЛЭЭ, ДАВТАМЖИЙН СУДАЛГАА

Ч. Алтангэрэл, Н. Жавхлан \*

*Хураангуй*—Орчин цагийн монгол хэлний өнөөгийн судалгааны төвшинд компьютер ашиглан хэлний нарийвчилсан шинжилгээ, судалгаа хийх зорилгоор МУИС-ийн Мэдээллийн технологийн сургуулийн Компьютер Хэл Шинжлэлийн Судалгааны Төвд (КХШСТ) монгол хэлний 5 сая үгтэй материалын сан (corpus) үүсгэсэн. Цахим санд тулгуурлан хэл шинжлэлийн олон сонирхолтой судалгаа, дүгнэлт хийж болох бөгөөд үүний нэг нь монгол хэлний үйл үгийн бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн “-гд” хэмээх бүтээврийн давтамжийн судалгаа юм. Уг өгүүлэл нь таван сая үгтэй монгол хэлний цахим сан [2], “Gogo.mn” сайтын 2007-2010 оны мэдээ, монгол хэлний задлуур програмд зориулсан санд [4] тулгуурлан бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн “-гд” бүтээврийн давтамжийг судалсан талаар, мөн судалгаанаас гарсан үр дүн, түүний хэрэглээ ач холбогдлын тухай өгүүлнэ.

*Түлхүүр үг*—Корпус хэл шинжлэл; цахим хэл шинжлэл; монгол хэлний үйл үгийн хэв; бусдын эрхэнд үйлдэгдэх “-гд” бүтээвэр

### УДИРТГАЛ

Хүн аль болох бүрэн төгс, товч, тодорхой, богино өгүүлбэрээр ярих нь ярилцаж байгаа хүнтэйгээ хурдан, бүрэн ойлголцох чухал үзүүлэлт юм [8]. Мөн товч тодорхой ярьснаар өгүүлэгч нь ярих энергиэ хэмнэдэг ба ингэж ярихыг ч ихэд эрмэлздэг. Үүнийг жишээгээр тайлбарлавал: “Би өчигдөр орой театрт тоглосон жүжгийг үзсэн” гэсэн өгүүлбэрийг харилцан ярианд “Өчигдөр орой жүжиг үзсэн” гэж богиносгож байна. Энд үйлийн эзэн нь өгүүлэгч өөрөө тул “би” гэсэн өгүүлэгдэхүүнийг орхисон, хаана үйл болсон гэдгийг чухалчлаагүй учир “театрт” гэсэн үгийг орхисон, “жүжиг” тоглогдсон нь ойлгомжтой учир “тоглосон” гэсэн үгийг орхисон, “жүжгийг” гэсэн үгний тусах нөхцөлийг орхисон байна. Дээрх өгүүлбэрийг богиносгосон байдлаар, ямар нэгэн утгын алдагдалгүйгээр сонсогч ойлгож чадна. Гэтэл орчин цагт үйл үгийн бусдын эрхэнд үйлдэгдэх “-гд” нөхцөлийг мэдэгдэхүйц их хэрэглэх болсон нь өгүүлбэрийн утгыг

\* МУИС, Мэдээллийн Технологийн Сургууль, Компьютер Хэл Шинжлэлийн Судалгааны Төв.

бүдгэрүүлэхийн зэрэгцээ хэлэхэд төвөгтэй, урт болгож байгаа нь илэрхий байна. Тухайлбал “1970 онд баригдсан барилга” гэсэн өгүүлбэрт үйлийн эзнийг нэмж утгыг нь лавшруулбал “1970 онд оросуудаар баригдсан барилга” болно. Харин “1970 онд барьсан барилга” гэж хэлээд үйлийн эзнийг нэмж утгыг нь сайжруулбал “Оросууд 1970 онд барьсан барилга” болно. Энэ хоёр хэлбэрийг харьцуулахад сүүлийн хувилбар нь хэлэхэд тун хялбар бөгөөд монгол хүний сэтгэхүйд шууд ойлгогдоно. Харин эхний хувилбар нь хэлэхэд төвөгтэй, ойлгоход хэцүү болж байна.

Сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээлэл, радио, телевизээр энэ мэт буруу өгүүлбэрийг ихээр ашиглаж байгаа нь мэдэгдэхүйц болсон бөгөөд цаашид хэрэглэсээр байвал монгол хүний сэтгэхүйд нөлөөлөх, монгол хэлний найруулга, утга төгөлдөр байдлыг алдуулах сөрөг үр дагавартай байж магадгүй гэсэн үүднээс “-гд” бүтээврийн өнөөгийн хэрэглээг өнгөрсөн үеийн хэрэглээтэй харьцуулж хэрхэн өөрчлөгдсөнийг харуулахыг зорилоо.

## СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ


Бид судалгаагаа КХШСТ-ийн үүсгэсэн монгол хэлний 5 сая үгтэй корпус [2] болон GoGo.mn сайтын 2007-2010 оны мэдээнд тулгуурлан хийсэн.

Корпус нь дан ярианы, дан бичгийн эсвэл яриа ба бичгийн эх холилдсон их хэмжээний бичвэрийн сан бөгөөд тийм бичвэрийн санг судалдаг салбар ухаан болох корпус хэл шинжлэл нь цахим хэл шинжлэлийн нэг салбар ухаанд тооцогддог. Монгол хэлний материалын санг цуглуулахад эхийг сонгохоос авахуулаад эх сурвалжуудыг хайж олох, эхийг эх сурвалжаас ‘txt’ хэлбэрт буулгах, эхийг цэвэрлэх, эхийг загварчлах, эхийн бүтцийг тодорхойлох зэрэг ажил багтана.

Монгол хэлний цахим санд уран зохиолын эхээс роман, тууж, өгүүллэг; сонин нийтлэлийн эхээс мэдээ, тэргүүн өгүүлэл (Үнэн сонины), нийтлэл, ярилцлага, сурвалжилга, өгүүлэл; хуулийн эхээс үндсэн хууль болон бусад хуулийг сонгон авсан болно. ХҮСНЭГТ I-д цахим сангийн эх сурвалж, ЗУРАГ 1-д нэг эхэд байсан үгийн дундаж тоог харуулав [2, 3].

## ХҮСНЭГТ I МОНГОЛ ХЭЛНИЙ ЦАХИМ САНГИЙН ЭХ СУРВАЛЖ

Найруулгын ангилал	Сайтаас авсан 2861 эх	Номноос авсан 24 эх	Сониноос авсан 1258 эх	Мултимедиа номноос авсан 10 эх
Хуулийн эх	<a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a>			
Уран зохиолын эх	<a href="http://www.elibrary.mn">www.elibrary.mn</a> <a href="http://www.mcl.edu.mn">www.mcl.edu.mn</a> <a href="http://www.bibirbeh.mn">www.bibirbeh.mn</a> <a href="http://www.on-toli.mn">www.on-toli.mn</a>	Л.Дашням Цаглашгүй цагаан салхи, Д.Пүрэвдорж Улаан зүүд.		Цэндийн Дамдинсүрэн, Монголын уран зохиолын дээж
Сонины эх	<a href="http://www.dailynews.mn">www.dailynews.mn</a> <a href="http://www.zuuniimedee.mn">www.zuuniimedee.mn</a>		Үнэн сонин	



Зураг. 1. Нэг эхэд буй үгийн дундаж тоо

Дан ганц бичвэр цуглуулаад үр ашиггүй юм. Тиймээс цуглуулсан бичвэр дээрээ тодорхой боловсруулалт хийн мэдлэг шингээн эргүүлэн судалж дахин ариулуулсан мэдлэг гаргаж авах нь чухал юм. Үүний тулд бид цуглуулсан корпусдаа үгийн аймгийн тэмдэглэгээг хадсан бөгөөд монгол хэлний үгзүйн задлуур [5] програм ашиглан бүтцийг нэг бүрчлэн задалсан. Энэ ажлын гол судалгааны материал нь ингэж үгийн бүтцээр задалсан корпус юм.

### МОНГОЛ ХЭЛНИЙ “ГД” БҮТЭЭВЭР

Бодот ертөнцийн юмс үзэгдлийн үйл хөдлөл, явц байдлыг нэрлэн заасан үгсийг үйл үг гэнэ. Хэлний дохио болох өгүүлбэрийг бүтээх, түүний бүтэц дэх үгсийн хэлзүйн хэлбэржилт, захирах захирагдах харьцааг тогтоох гол тулгуур нь үйл үг байдаг.

Тухайн үйлийг гүйцэтгэх эзэн (өгүүлэгдэхүүн буюу subject) үйлэнд өртөх юм (тусагдахуун буюу object) хоёрт харьцах харьцааг зааж, залгасан үйл үгийнхээ захирах чадварт нөлөөлдөг үйлээс үйл үг бүтээх дагаврын тусламжтай илэрдэг хэлзүйн айг үйл үгийн хэв гэнэ. Иймээс хэв нь үйл үгийн тусах, эс тусах шинж, захирах чадвартай нягт холбоотой. Энэ шинжээр нь үйл үгийн хэвийн нөхцөлийг үйлээс үйл үг бүтээх дагавар гэж үздэг (ХҮСНЭГТ II) [1].

### ХҮСНЭГТ II Үйл үгийн хэвийн дагавар

Хэв	Дагавар	Жишээ
Өөрөө үйлдэх	0	Яв, оч, бич
Бусдаар үйлдүүлэх	-уул <sup>2</sup> , -лга <sup>4</sup> , -аа <sup>4</sup> , -га <sup>4</sup>	Явуул, шатаа, суулга, олго
Хамтран үйлдэлцэх	-лц	Ярилц, хийлц
Бусдын эрхэнд үйлдэгдэх	-гд, -д, -т	Бодогд, үзэгд, олд, авт
Харилцан үйлдэгдэх	-лд	Тэмцэлд, барилд

Нийлмэл хэв	-га+уул	Гаргуул
	-а+лга	Шатаалга
	-лга+уул	Суулгуул
	-уул+уул	Хэвтүүлүүл

### МОНГОЛ ХЭЛНИЙ “ГД” БҮТЭЭВРИЙН ДАВТАМЖИЙН СУДАЛГАА

Бид үйл үгийн хэвийн дагавраас “Бусдын эрхэнд үйлдэгдэх “-гд” дагаврын (бүтээвэр) тухай судалгааг 5 сая үгтэй цахим сан болон 19,8 сая үгтэй 2007-2010 оны gogo.mn сайтын үгийн санд тулгуурлан бүтээврийн хэрэглээ, давтамжийн судалгааг гаргалаа.

Уг судалгаа нь монгол хэлний найруулгын (албан бичиг, шинжлэх ухаан, сонин нийтлэл, уран зохиол гэсэн үндсэн дөрвөн төрөл мөн сүүлийн үед зарим эрдэмтэд ярианы найруулгыг тав дахь төрөл болгон нэмсэн) олон алдаа дутагдлаас бичил хэсгийг засч уран яруу, утга тодорхой, товч зөв зүйтэй болгож, бичгийн хэл найруулга цаашлаад ярианы хэл найруулгад чухал хэрэг болох юм.

Судалгаа гаргахдаа эхлээд хэдэн төрөл үгэнд хэдэн “-гд” бүтээвэртэй үг орсон, дараа нь давтамжийн тоог нь гаргасан. 5 сая үгтэй цахим сангаас “-гд” бүтээвэртэй үгийн төрлийн судалгаа гаргаж үзэхэд хуульд хамгийн их, уран зохиолд хамгийн бага хэрэглэж байна. (ХҮСНЭГТ III)

#### ХҮСНЭГТ III “-гд” бүтээвэртэй үгийн судалгаа

Эхийн төрөл	Нийт үгийн төрөл	“-гд”-тэй үгийн төрөл	Үзүүлэлт
Уран зохиол	76494	1599	2.09%
Хууль	14993	649	4.33%
Нийтлэл	111336	3197	2.87%
Үнэн сонин	32930	965	2.93%

“-гд” бүтээвэртэй үгийн давтамжийн судалгаа гаргаж үзэхэд хуульд хамгийн их давтамжтай, харин үнэн сонинд хамгийн бага давтамжтай хэрэглэж байна. (ХҮСНЭГТ IV)

#### ХҮСНЭГТ IV “-гд” бүтээвэртэй үгийн давтамжийн судалгаа

Эхийн төрөл	Нийт давтамж үгийн	“-гд”-тэй давтамж үгийн	Үзүүлэлт
Уран зохиол	1013194	6932	0.68%
Хууль	577640	6058	1.04%
Нийтлэл	2241445	19518	0.87%
Үнэн сонин	840494	5061	0.6%

Мөн GoGo.mn сайтын 2007-2010 оны давхардсан тоогоор 19,8 сая үгийн сангаас “-гд” бүтээвэртэй үгийн судалгаа гаргахад жил ирэх тусам их хэрэглэсэн буюу 2010 онд хамгийн их хэрэглэсэн байна. (ХҮСНЭГТ V)

ХҮСНЭГТ V “-ГД” БҮТЭЭВЭРТЭЙ ҮГИЙН СУДАЛГАА


GoGo.mn	Нийт үгийн төрөл	“-гд”-тэй үгийн төрөл	Үзүүлэлт
2007 он	163184	4046	2.47%
2008 он	195645	4698	2.4%
2009 он	166988	4295	2,57%
2010 он	98965	2752	2,78%

“-гд” бүтээвэртэй үгийн давтамжийн судалгаа гаргахад жил ирэх тусам давтамж нь буурч, төрөл нь ихэссэн байна. (ХҮСНЭГТ VI)


ХҮСНЭГТ VI “-ГД” БҮТЭЭВЭРТЭЙ ҮГИЙН ДАВТАМЖИЙН СУДАЛГАА

GoGo.mn	Нийт давтамж үгийн	“-гд”-тэй давтамж үгийн	Үзүүлэлт
2007 он	4613547	132718	2.87%
2008 он	6962201	191421	2.74%
2009 он	6025207	167592	2.78%
2010 он	2199616	20358	0.92%
<b>Нийт</b>	<b>19800571</b>	<b>512089</b>	<b>2.32%</b>

Монгол хэлний “-гд” бүтээвэртэй үгийн судалгаагаа нэгтгэж графикаар харууллаа. (ЗУРАГ I, II)



Зураг. 2. Нийт сангийн үгийн төрөл, “-гд” бүтээвэртэй үгийн төрлийн үзүүлэлт



Зураг. 3. Нийт сангийн үгийн давтамж, “-гд” бүтээвэртэй үгийн давтамжийн үзүүлэлт

### “ГД” БҮТЭЭВРИЙГ ТҮЛХҮҮ ХЭРЭГЛЭХ БОЛСОН ШАЛТГААН

Монгол хэл соёлд өнөөдөр европ хэл соёл нөлөөлж байгаа нь үнэн. Гэхдээ монгол хэл бол алтай язгуурын залгамал бүтэцтэй хэл. Энэхүү залгамал хэлнийх нь бүтэц байгууламж нь монгол хэлийг аврах хүчин зүйл болдог [9]. Гадаад үг хэчнээн орлоо ч монгол хэл шингээх чадвар сайтай. Харин гадаад хэлнээс орчуулга хийхдээ үгчилж буруу орчуулснаас монгол хэлний бичгийн хэлэнд алдаа дутагдал нэмж байна.

Бид КХШСТ-д цуглуулсан англи-монгол зэрэгцсэн корпусын монгол орчуулгад байгаа “-гд” бүтээвэртэй өгүүлбэрийг шинжилж үзэхэд англи хэлний бусдын эрхэнд үйлдэгдэх хэлбэрийг шууд дуурайн орчуулсан нь харагдаж байсан. Сонирхолтой нь тэдгээр өгүүлбэрийг бүгдийг нь “-гд” бүтээвэр ашиглахгүйгээр зөв утга, найруулгатай орчуулж болохоор байсан. ХҮСНЭГТ VII-д зарим жишээг харуулав.

### ХҮСНЭГТ VII АНГЛИ ХЭЛНЭЭС МОНГОЛ ХЭЛРҮҮ ОРЧУУЛСАН

№	Англи	Монгол
1	New Requirements at U.S. Borders	АНУ-ын хил дээр <b>тавигдаж</b> буй шинэ шаардлагууд
2	I noticed that American students are very open to talk about any topic.	Ямарч сэдвээр Америк оюутнууд ярилцахдаа маш их нээлттэй болох нь <b>харагдсан.</b>
3	In short, I never imagined that I would have a personal connection to the Nobel Prizes.	Товчхондоо би хувьдаа Нобелийн шагналтай ингэж <b>холбогдоно</b> гэж төсөөлөө ч үгүй байсан.

4	Najwa Nasr discovered a little-known history of Lebanese immigration while visiting the United States on research exchange program.	Нажва Наср АНУ-д судалгааны солилцооны хөтөлбөрөөр зочилж байхдаа Ливан цагаачдын бараг <b>мэдэгдээгүй</b> түүхийг нээсэн байна.
5	For 10 days, I shuttled to the archives with insatiable eagerness, and stayed from open until close.	10 хоногийн турш би архиваар ухаангүй хэрэн хэсч, <b>нээгдэхээс нь хаагдах</b> хүртэл ажиллаж байсан.

Үүнээс үүдэж монгол хэлний найруулга хэрэглээ буруу болж байна гэж бид үзэж байна. Бид илтгэлдээ монгол хэлийг хамгаалах асуудлыг бичиг үсэгтэй нь хамтатгаж ярих ёстой гэдгийг хөндөж байна. Учир нь бичгийн хэлний нэг үүрэг нь ярианы хэлийг чиглүүлэх байдаг. Тиймээс бичгийн хэлэндээ ийм алдаатай, найруулга буруу бичээд байвал монгол хэлний дархлаа маш их муудна. ХҮСНЭГТ VIII-д GoGo.mn сайтад хамгийн их давтамжтай “-гд” нөхцөлтэй үгсийг харуулав.

#### ХҮСНЭГТ VIII “GoGo.MN” САЙТ 2010 ОН

№	Давтамж	Үг	Задлал
1	197	байгуулагдсан	байгуул+гд+сан
2	188	сонгогдсон	сонго+гд+сон
3	109	хамрагдсан	хамар+гд+сан
4	105	тогтоогдсон	тогт+оо+гд+сон
5	66	зөвшөөрөгдсөн	зөвшөөр+гд+сөн
6	63	ажиглагдаж	ажигла+гд+ж
7	51	тусгагдсан	тусга+гд+сан
8	49	хийгдээгүй	хий+гд+ээ+гүй
9	48	тогтоогджээ	тогтоо+гд+жээ
10	47	олгогдсон	олго+гд+сон
11	40	бүртгэгджээ	бүртгэ+гд+жээ
12	39	ажиглагдсан	ажигла+гд+сан
13	37	өөрчлөгдсөн	өөрчил+гд+сөн

14	36	шийдэгдээгүй	шийд+гд+ээ+гүй
15	31	худалдаалагдаж	худалдаал+гд+ж
16	12	баривчлагдсан	баривчил+гд+сан
17	12	төлөвлөгдсөн	төлөвлө+гд+сөн
18	28	хангагдсан	ханга+гд+сан
19	27	шийтгэгдсэн	шийтгэ+гд+сэн
20	1	гадуурхагдана	гадуурх+гд+на
21	26	чөлөөлөгдсөн	чөлөөл+гд+сөн
22	25	батлагдсаны	батал+гд+сан+ы
23	25	нотлогдсон	нотол+гд+сон
24	24	суллагдсан	сулла+гд+сан
25	1	гутаагдагсадад	гутаа+гд+гсад+д
26	16	чиглэгдсэн	чиглэ+гд+сэн
27	1	доромжлогдсон	доромжил+гд+сон
28	16	шинэчлэгдэж	шинэчил+гд+ж
29	16	үйлдэгдсэн	үйлд+гд+сэн
30	14	саатуулагдсан	саатуул+гд+сан
31	14	солигдож	соль+гд+ж
32	14	сонсогдсон	сонс+гд+сон
33	14	сэжиглэгдэж	сэжиглэ+гд+ж
34	13	зарцуулагддаг	зарцуул+гд+даг
35	13	нийтлэгдсэн	нийтэл+гд+сэн
36	1	давтагдахын	давт+гд+х+ын
37	11	томилогджээ	томил+гд+жээ



38	11	тэмдэглэгдсэн	тэмдэглэ+гд+сэн
39	11	уламжлагдан	уламжил+гд+н
40	11	хаагдана	хаа+гд+на

Бид “-гд” бүтээврийн хэрэглээ, давтамжийг гаргахын тулд цахим сан ашигласан. Тухайн санд найруулгын бүх төрлөөс орсон. (найруулгын төрлийг дээр дурдсан) Тиймээс багахан тодруулга хийх журмаар тухайн үед (1985-1987 онд) хамгийн их үнэн зөв, хурдан шуурхай мэдээлэлтэй; найруулга, зөв бичгийн алдаагүй; хяналт, шалгалт сайн гэгддэг байсан “Үнэн сонин”-ы “-гд” бүтээвэртэй бүх өгүүлбэрийн найруулгын алдааг шалгаснаас жишээ болгож 5 өгүүлбэр орууллаа.

Жишээ:

1. «Улс ардын аж ахуйд **ашиглагдахгүй** байгаа нөөцийг дайчлан ашиглахад нам, ард түмний гол анхаарал, хүч чармайлтыг төвлөрүүлэх нь шинэ таван жилийн бүтээн байгуулалтын үеийн намын эдийн засгийн бодлогын хойшлуулшгүй зорилт мөн» гэж нөхөр Ж. Батмөнх Намын Төв Хорооны XI бүгд хурал дээр хэлсэн энх утга урган гарсан шинэ оны ажлыг тодорхойлж байна. (Үнэн сонин, № 16280, 1986.01.03, “Таван жилийн гараа”)

2. Үнэн байдлыг илэн далангүй мэдээлж, шийдвэрлэх арга замыг зөвлөн ярилцаж, хамтын оюун ухаан, нэгдмэл хүч чармайлтаа, **тавигдсан** зорилтыг шийдвэрлэх тухайд боловсон хүчний зонхилох хэсгийн сэтгэлгээнд шинэчлэлт өөрчлөлт **дутагдсаар** байна. (Үнэн сонин, №16662, 1987.03.25, “Боловсон хүчний шинэ сэтгэлгээ”)

3. Шинэ арга барил шинэ сэтгэлгээгээр ажиллах тухай яриа хичнээн мэргэн цэцэн байлаа ч гэсэн тодорхой ажлаар **нотлогдохгүй** бол тэр нь хэлбэр төдий халхавч юм. (Үнэн сонин, №16662, 1987.03.25, “Боловсон хүчний шинэ сэтгэлгээ”)

4. Шарын голын нүүрсний уурхайн захиргаа төлөвлөгөө биелүүлэхийн тулд 16 мянга гаруй хүн цаг илүү ажиллуулснаас Болж үйлдвэрлэлийн жигд ажиллагаа **алдагдаж**, технологи **зөрчигдөж**, үргүй зардал **нэмэгджээ**. (Үнэн сонин, №16808, 1987.09.11, “Захиргааны аргаас эдийн засгийн аргад”)

5. Түүнчлэн ХБХБ тэмдгийн норм биелүүлэх ажлыг хэлбэрддэг дутагдал оршсоор байгаа, болох нормын зарим үзүүлэлтийг спортын өндөр зэрэгтэй тамирчин ч биелүүлж чадахааргүй **зохиогдсоныг** Биеийн тамир, спортын улсын хороо анхаарах хэрэгтэй. (Үнэн сонин, №16844, 1987.03.23 (“Спортыг нийтэд хүргэе”) гэх мэт найруулгаас болж:

- Найруулга товч тодорхой, оновчтой, ойлгомжтой, энгийн төв, өгүүлсэн зүйл нь итгэлтэй, утга төгөлдөр байх шинжээ алдсан байна. Тодруулбал товч бичиж найруулахын тулд хэлний хэмнэлтийн зарчмыг нилээд хэмжээгээр хэрэглэдэг. Товч байхын хэрээр утга нь тодорхой байдаг.

- Бичлэгийн хувьд бусад төрөл зүйлтэй харьцуулахад сонины хэл найруулга хамгийн энгийн, ойлгоход хялбар, цөөн үгээр өргөн агуулга гаргасан байх шинжээ алдсан байна.
- Мөн “-гд” бүтээврийг их ашигласнаар найруулга ойлгомжгүй болохоос гадна, эзэн биегүй үйл их болж утга өөрчлөгдсөн байна. тиймээс “-гд” бүтээврийг хасч эзэн биеийг нэмж зөв найруулах.
- “-гд” бүтээврийг нэмснээр хэлэхэд төвөгтэй, урт үе, ойлгомжгүй дутуу өгүүлбэр үүсч байна.

## Дүгнэлт

Судалгааны ажлыг ном сонин, нийтлэл, телевиз радио, цахим сайт гэх мэт бүх мэдээллийн хэрэгслээр монгол хэлний үйл үгийн бусдын эрхэнд үйлдэгдэх “-гд” бүтээврийг их хэрэглэж байгаа нь илт ажиглагдах болсон тул бид энэхүү асуудлыг судалж шинжлэхээр зорьсон билээ. Үүний тулд цахим санд тулгуурлан статистик тоо баримт гаргахад их сонирхолтой зүйл гарч ирсэн. Үүнд:

- 1985-1987 онд нийтэлж байсан үнэн сонинд энэхүү бүтээврийг өнөөгийн мэдээллийн хэрэгслээс харьцангуй бага буюу нийт үгийн 0,6% -д хэрэглэж байсан байна. Гэтэл өнөөгийн хүмүүсийн маш их мэдээлэл авдаг gogo.mn сайтын 2007-2010 оны өгүүлэлд судалгаа хийхэд 2.0-2,78%-тай хэрэглэж байна.
- Мөн gogo.mn сайт дахь уг бүтээврийн хэрэглээ жил ирэх тусам нэмэгдсэн байна. Тодруулбал 2007 онд 2.47%, 2008 онд 2.4%, 2009 онд 2.57%, 2010 онд 2.78% гэх мэт. Энэ нь дан ганц gogo.mn сайт ч биш бусад бүх мэдээллийн хэрэгсэл болон хүмүүсийн дунд энэ мэтээр нэмэгдэж байгаа болов уу гэсэн таамаг дэвшүүлж байна.

Уг бүтээврийг ихээр хэрэглэх болсон шалтгааныг бид гадаад хэлнээс (ялангуяа англи) орчуулга хийхдээ үгчилж, дууриаж орчуулдаг ба эх хэлээ сайтар эзэмшээгүй орчуулагч өөрөө, мөн түүний орчуулгыг уншсан, сонссон хүмүүс дуурайснаас үүдэлтэй гэж үзэж байна.

Бичгийн хэлний өөрчлөлтийг дагаж ярианы хэл өөрчлөгдөх нь зүй ёсны. Тиймээс бичгийн хэлэнд уг бүтээврийг их хэрэглэж байгаа нь ярианы хэлэнд нөлөөлж, үгийг хэлэхэд төвөгтэй, урт үетэй урт үг, утга тодорхойгүй урт өгүүлбэр үүсч хэл найруулга алдаатай болох сөрөг үр дагавартай юм.

Бид судалгааны ажлаараа монгол хэлэнд бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн “-гд” бүтээвэр маш их хэрэглэж байгааг харуулахыг зорьсон бөгөөд энэ нь зөв буруу аль нь болохыг дүгнэхийг хүссэнгүй. Энэ талаар та бид, монгол хэл судлалын томоохон эрдэмтэд оюун ухаандаа тунгаан шийдэх биз ээ.

## НОМЗҮЙ

- [1] Цэгмид С, Оюунцэцэг Ж., Орчин цагийн монгол хэлний үг зүй, УБ, 1997
- [2] Пүрэв Ж., нар, *Монгол хэлний тулгуур цахим байгууламж*, МУИС, Азийн судалгааны төв, Улаанбаатар, 2006.
- [3] Энхжаргал М, Пүрэв Ж, Нанзадрагчаа Д., Электрон бичвэрт суурилсан монгол хэлний үгийн болон үсгийн давтамжийн судалгаа, Хүрэлтогоот, Улаанбаатар, 2012
- [4] Э.Мөнх-Учрал, Монгол хэлний задлуур програмд зориулсан сан, Докторын диссертаци, Улаанбаатар, 2010
- [5] М.Золжаргал, Кирилл-Монгол онлайн толь, Хүрэлтогоот-2012, Улаанбаатар, 2012
- [6] Chagnaа Altangerel and Jaimai Purev: *Web as a corpus*, Mongol Studies Research papers, vol. XXXI (328), 2010, ISSN 1997-1826 (in Mongolian)
- [7] Базаррагчаа М., Утгын чуулган, Уб, 2002
- [8] Лувсанвандан Ш., ОЦМХ-ний бүтэц, Монгол хэлний бүтээвэр, үг, үгүүлбэрийн судлал, Уб, 2010
- [9] Док., Проф Г.Гантогтох, МУИС, МХШ Тэнхимийн багш, Өнөөдөр сонин, Улаанбаатар, 2012

## ABSTRACT

For modern mongolian language computer based analysis framework, Research Center of Computer and Language, SIT, NUM has created a corpus with 5 million words. This corpus can be used many researches and in this paper we purpose to study the frequency of “-гд” of mongolian verbs. We have done experiments in [2], [4] databases and this paper shows our experimental results.